

№	Асуулт	Хариулт
1	Хувь нийлүүлсэн хөрөнгийн мөнгөн хөрөнгөд Үл хөдлөх, программ хангамж орох уу?	Үгүй, Зөвхөн мөнгөн хөрөнгө байхыг шаардаж байгаа
2	Хувь нийлүүлсэн хөрөнгийн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл ИЕО-оос олсон орлого байх тохиолдолд яах вэ?	Татвар төлсөн байх шаардлагатай.
3	Хувь нийлүүлсэн хөрөнгийг хэдий хугацаанд байршуулах вэ?	Хороонд хүсэлтээ өгөөд бүртгүүлэх хүртлээ байршуулсан байх шаардлагатай.
4	MNS ISO/IEC 27001 толгой компани дээр авахад охин компанид хамаарах уу?	ВХҮҮ-ийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан үйлчилгээг үзүүлэх гэж буй байгууллага MSN ISO/IEC 27001-ийг баталгаажуулсан байх шаардлагатай.
5	ВХҮҮ бүртгэлийн журам дээр 3.5-д заасан ажилтан нь давхар ажил хавсран эрхэлдэггүй байна гэсэн нь гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно гэж заасантай харшилдаж байна. Үүнийг хэрхэн зохицуулах вэ?	ВХҮҮ бүртгэлийн журам дээр 3.5-д заасан ажилтан эсхүл нэгж нь тухайн байгууллагад давхар ажил эрхлэх боломжгүй юм. Хэрэв энэ үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд энэ заалт хамаарахгүй юм.
6	ВХҮҮ-ээр хүсэлт гаргахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ хэд байх вэ?	ВХҮҮ-ийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан үйлчилгээг эрхлэх хүсэлт гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ тус бүр 400.0 сая төгрөгөөс доошгүй байна.
7	Шилжилтийн үеийн зохицуулалт гэж юу вэ?	1. 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хойш дөрвөн сарын хугацаанд аливаа компанийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй. 2. 2022 оны 02 дугаар сарын 25-аас өмнө виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байсан этгээд 6 дугаар сарын 25-аас хойш гурван сарын дотор хуульд заасан шаардлагыг хангаж, хороонд бүртгүүлнэ.
8	Шинээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх гэж байгаа хуулийн этгээд хороонд хүсэлтээ хэзээ өгөх вэ?	Хороонд 2022 оны 9 дүгээр сарын 25-аас хойш хүсэлт гаргаж, бүртгүүлнэ. Бүрэн гүйцэт баримт бичгийг хүлээн авснаас хойш зургаан сарын дотор бүртгэх асуудлыг хороо шийдвэрлэнэ.
9	Гадаадын хөрөнгө оруулалттай компани ВХҮҮ-ээр хүсэлтээ өгч болох уу?	Гадаадын хөрөнгө оруулалттай ч МУ-д бүртгэлтэй компани бол хуульд заасан ВХҮҮ-ээр хүсэлтээ өгч болно.
10	MNS ISO/IEC 27001 сертификатыг заавал баталгаажуулах ёстой юу, зүгээр үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байж болох уу ?	Тухайн стандарт нь мэдээллийн аюулгүй байдлын менежмент, тогтолцооны стандарт учир баталгаажуулах эрх бүхий байгууллагаар заавал баталгаажуулна.
11	Outsourcing хийж байгаа байгууллага MNS ISO/IEC 27001 сертификат авчихсан тул манай байгууллага нэвтрүүлэхгүй байж болох уу?	Уг стандарт нь мэдээллийн аюулгүй байдлын менежмент, тогтолцооны стандарт учир заавал өөрийн байгууллагад нэвтрүүлнэ. Outsourcing хийж байгаа байгууллага нэвтрүүлсэн байгаа нь тус стандартын нэг шаардлагыг хангасныг илэрхийлнэ.
12	ВХҮҮ-ийн хуулийн 6.1.1-с 6.1.5 хүртэлх үйл ажиллагааг заавал бүгдийг нь авах шаардлагатай юу?	Бүгдийг нь авах шаардлагагүй, тус тусад нь авч болно.
13	Виртуал хөрөнгийн цахим түривчний үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэж ойлгох уу?	ВХҮҮ-ийн тухай хуулийн 6.1.1-с 6.1.5 хамаарах блокчэйн технологид суурилсан токен бүхий үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд шинж чанараас нь хамааруулан ВХҮҮ мөн гэж үзнэ.
14	Виртуал хөрөнгийн цахим түривчинд байгаа виртуал хөрөнгөөр бараа материал худалдан авч болох уу?	Болохгүй. Монгол улсын мөнгөн тэмдэгтийн тухай хуулиар Монгол улсын нутаг дэвсгэр дээр зөвхөн төгрөгөөр арилжаа хийж болно. Мөн виртуал хөрөнгийг арилжаа хийх тухай сурталчилгаа хийж болохгүй.
15	NFT-г виртуал хөрөнгө гэж үзэх үү?	Блокчэйн технологид суурилсан токен учир хуулийн 6.1.1-с 6.1.5-т заасныг шинж чанарын хувьд хангаж байгаа тул виртуал хөрөнгө гэж үзнэ.
16	Аль нэг marketplace дээр NFT гаргаж болох уу?	Болохгүй. ВХҮҮ-ийн тухай хуулийн 17.2-т заасны дагуу 2022 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл хуулийн 6.1.1-с 6.1.5-т заасан үйл ажиллагааг шинээр явуулахыг хориглосон.
17	Виртуал хөрөнгөтэй холбоотой сурталчилгааг олон нийтийн хэрэгслээр хэзээ явуулж болох вэ?	Шилжилтийн үеийн зохицуулалт дуусаж, хороонд хүсэлтээ өгч ВХҮҮ-ийн тухай хуулийн 6.1.5-д заасан үйл ажиллагааг эрхлэгчээр бүртгүүлсэн тохиолдолд явуулж болно.

18	Хүсэлт гаргагч нь заавал ТУЗ-тэй байх ёстой юу?	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журмын 3.1-т зааснаар хүсэлт гаргагч нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна.
19	ВХҮҮ -ийн бүртгэл хэзээ эхлэх вэ?	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т зааснаар хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш 4 сарын дараа буюу 2022 оны 6 дугаар сарын 27-оос эхлэн бүртгэнэ.
20	ВХҮҮ-ээр бүртгүүлэхэд материал дутуу эсхүл шаардлага хангаагүй тохиолдолд яах вэ?	Хүсэлт гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу бол энэ тухай хүсэлт гаргагчид мэдэгдэх бөгөөд хүсэлт гаргагч уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ВХҮҮ-ийн тухай хуульд заасан баримт бичгийн бүрдлийг хангаж бүртгүүлэх хүсэлтээ ажлын 30 өдрийн дотор дахин гаргаж болно.
21	Улсын мөнгөн тэмдэгт болон зохицуулалт үйлчилгээний хөлсийг бүртгүүлэхээр материал өгөхдөө төлчихсөн байх шаардлагатай юу?	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.10-т зааснаар Хорооны хурал болох өдрөөс өмнө төлсөн байх шаардлагатай.
22	Эхлээд цахимаар бүртгүүлсний дараа цаасаар материалаа өгөх үү?	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журмын 5.1-д заасны дагуу цахим болон цаасаар хүлээж авна.
23	Хорооноос ВХҮҮ-ийн материалыг хэдий хугацаанд хянан үзсэний дараа хариу мэдэгдэх вэ?	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу 6 сарын дотор бүртгэх асуудлыг Хороо шийдвэрлэнэ. Харин шилжилтийн үеийн зохицуулалтаар өмнө үйл ажиллагаа эрхэлж байсан ВХҮҮ-чид тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу 9 дүгээр сарын 27-ны дотор бүртгүүлсэн байх шаардлагатай.
24	Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын дагуу ВХҮҮ-ийн ямар этгээдээс холбогдох мэдээллийг авч хүргүүлэх вэ?	Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-т "эрх бүхий албан тушаалтан"-аар "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээд" гэж заасан.
25	ВХҮҮ-ээр бүртгүүлж чадахгүй бол яах вэ?	ВХҮҮ-ийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаа зогсоно.

6-р сар 27, 2022  
Шилжилтийн үеийн бүртгэл эхэлнэ

9-р сар 26, 2022  
Шилжилтийн үеийн  
бүртгэл дуусна

2022.06.27

Шилжилтийн үеийн бүртгэл

2022.09.26

